



Захиргааны хэм хэмжээний  
актын улсын нэгдсэн сан  
2021 оны 11 сарын 09  
едрийн 5536 дугаарт бүртгэгч

БАЯНХОНГОР АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ХУРАЛДААНЫ ТОГТООЛ

2021 оны 10 сарын 05 өдөр

Дугаар 5/УУ

Нөмрөг

Автотээврийн болон өөрөө явагч хэрэгсэлд  
ногдуулах албан татварын хэмжээг шинэчлэн  
тогтоох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.2-ын "д", 19 дүгээр зүйлийн 19.1.4, 25 дугаар зүйлийн 25.1, Автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татварын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1, 5.3, Захиргааны ерөнхий хуулийн 64 дүгээр зүйлийн 64.1 дэх заалтыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит бус V хуралдаанаас ТОГТООХ нь:

1. Аймагт бүртгэлтэй автотээврийн болон өөрөө явагч хэрэгсэлд жилд ногдуулах албан татварын хэмжээг хавсралтаар шинэчлэн баталсугай.
2. Автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татварын хэмжээг мөрдүүлэх, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж ажиллахыг аймгийн Засаг дарга (Д.Мөнхсайхан)-д үүрэг болгосугай.
3. Энэ тогтоолын хэрэгжилтэнд хяналт тавьж захиргааны хэм хэмжээний актын улсын бүртгэлд шинэчлэн бүртгүүлэхийг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч (Т.Норов)-т даалгасугай.
4. Энэхүү тогтоол гарсантай холбогдуулан аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 46 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА

Э.ЭНХБАТ

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын  
2021 оны 10 дугаар сарын 25-ны өдрийн ээлжит бус  
V хуралдааны 5/17 дугаар тогтоолын хавсралт

АВТОТЭЭВРИЙН БОЛОН ӨӨРӨӨ  
ЯВАГЧ ХЭРЭГСЛИЙН АЛБАН ТАТВАРЫН ХЭМЖЭЭГ  
ШИЙЭЧЛЭН ТОГТООСОН ЖАГСААЛТ

| №                    | Авtotээврийн болон өөрөө явагч хэрэгслийн төрөл                        | Төлбөрийн хэмжээ /төгрөг/          |           |
|----------------------|--|------------------------------------|-----------|
| 1                    | 2  | 3                                  |           |
| 1                    | 2 дугуйтай мотоцикл  | 3,000.0                            |           |
| 2                    | 3 дугуйтай мотоцикл  | 4,500.0                            |           |
| 3                    | Суудлын автомашин /цилиндрийн багтаамжийн нэг см куб тутамд төгрөгөөр/ | 2001 см <sup>3</sup> хүртэл        | 18        |
|                      |  | 2001-3001 см <sup>3</sup>          | 20        |
|                      |  | 3001 см <sup>3</sup> болон түүнээс | 28        |
| 4                    | Микроавтобус   | 15 хүртэл хүний суудалтай          | 40,000.0  |
| 5                    | Автобус  |                                    | 60,000.0  |
| 6                    | Ачааны автомашин   | 1 хүртэл тн-ын даацтай             | 25,000.0  |
|                      |  | 1-2 тн-ын даацтай                  | 35,000.0  |
|                      |  | 2-3 тн-ын даацтай                  | 45,000.0  |
|                      |  | 3-5 тн-ын даацтай                  | 55,000.0  |
|                      |  | 5-8 тн-ын даацтай                  | 90,000.0  |
|                      |  | 8-10 тн-ын даацтай                 | 100,000.0 |
|                      |  | 10-20 тн-ын даацтай                | 110,000.0 |
|                      |  | 20-30 тн-ын даацтай                | 165,000.0 |
|                      |  | 30-40 тн-ын даацтай                | 220,000.0 |
|                      |  | 40-50 тн-ын даацтай                | 260,000.0 |
|                      |  | 50-60 тн-ын даацтай                | 320,000.0 |
|                      |  | 60-70 тн-ын даацтай                | 400,000.0 |
|                      |  | 70-80 тн-ын даацтай                | 420,000.0 |
| 80-90 тн-ын даацтай  | 480,000.0  |                                    |           |
| 90-100 тн-ын даацтай | 500,000.0  |                                    |           |
| 100-аас дээш даацтай | 550,000.0  |                                    |           |
| 7                    | Тусгай зориулалтын автомашин   |                                    | 22,500.0  |
| 8                    | Трактор, өөрөө явагч бусад хэрэгсэл                                    |                                    | 14,000.0  |
| 9                    | Бага оврын трактор   |                                    | 7,000.0   |
| 10                   | Чиргүүл /даацаар 1 тн тутамд/  |                                    | 7,000.0   |